

**III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА
НЭГ. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХУУЧИН БАРИЛГЫН
ЗАСВАРЫН АЖИЛ**

Засварлах гэж буй барилга нь тэнхлэгээрээ 26,28м х11,13м-ийн хэмжээтэй 1 давхар барилга болно. Давхрын өндөр 2,7 м, А нуруу давхрын адарын хөндийтэй юм. Тоосгон 64мм өргөнтэй өрөгт бүтээтцэй, модон хучилттай, А нуруу давхрын адарын хөндийтэй, цутгамал бетон суурь, банзан шалтай барилга юм. (Загвар зургийг хавсаргасан.)

Барилгын хийц:

Үндсэн хийц – Тоосгон 64мм өргөнтэй өрөгт бүтээтцэй, модон хучилттай

Гадна хана – 64мм тоосгон ханатай

Хучилт – Модон хучилттай

Дотор хана – 120мм,380мм тоосгон хана, шавардлагатай

Дээвэр – модон хучилттай А нуруу буюу давхрын адарын хөндийтэй

Цонх, хаалга-Модон рамтай вакум мөн модон рамтай 2 давхар шилтэй, 2 төрлийн цонхтой

Шал-Модон банзан шалтай .

№	Нэр төрөл	Тоо хэмжээ	Чанар байдал
1	Хуучин будагтай ханын гадаргууг хусаж цэвэрлэх,	580м ²	Хуучин барилгын ханын хагарч хөндийрсөн хэсгийг хусаж унагаж грунт түрхэж, ремонт нөхөөс хийж, сайн чанартай зүлгүүр тавина.
2	Цонхны засвар	13 ширхэг	Углуургыг авах, ховилыг задлах, модон цонхыг солих, вакум цонхыг засварлах
3	Гадна ханын засвар	202м ²	Гадна талын хананы хагарч муудсан хэсгийг янзлах, барилгын хаяавч хэсгийн хагарсан тоосгыг янзлах, дотор ханыг ариглетан хавтангаар хийх, гадна дотор талаас нь ТК боловсруулж сайжруулах
4	Дотор хана, хамар хана	579 хэсэг	Анги танхимууд болон коридорын ханыг ТК боловсруулж, сайжруулах
5	2м2 хүртэлх талбайтай модон хаалга угсрах	7 ширхэг	Хаалганы хананд бэхлэгдсэн углуургыг авах, ховилыг задлах, чанартай модон хаалга суулгах
6	Металл дүүжин тааз хийх	293м ²	Хөнгөн цагаан рамтай 60х60 хэмжээтэй дүүжин таазыг тросс ба булан төмрөөр зүүж, сайтар бэхлэх
7	Гэрэлтүүлэг	37 ширхэг	Дүүжин таазанд QWO3-20W 220V 50Hz BA маркийн 60х60 өдрийн гэрлийг суурилуулах

8	Ханыг чанартай сайн будгаар будах	580м ²	Хананы өндөр, өндрийн түвшин хүртэл тосон будгаар 2 үе будна. Тааз хүртэл эмульсээр 2 үе будна.
9	Шал	258м ²	Өрөө тус бүрд ТК боловсруулалт хийх, Ардаа цавуутай олон үет PVC хулдаасан хавтанцар өнгөлгөөг модон шаланд чанартай наах.
10	Дээвэр	4 хэсэг	Дээвэр дээр ус зайлуулах хоолойг нэмэлтээр оруулах
11	Коридор		Ханыг будах, шаланд хулдаас хийх, гэрэлтүүлэг нэмэх